

ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэ
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт							
“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжид мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дүнд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хугаарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.		Хэрэгжилтийг зохион байгуулсан журам, дүрэм, заавар, зөвлөмжийн тоо	2023 онд хэрэгжилтийг зохион байгуулсан журам, дүрэм, заавар, зөвлөмжийн тоо	Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцсон байна.	Засгийн газрын 2024 оны 10 дугаар тогтоолоор тэтгэвэр бодоход баримтлах итгэлцүүрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан нийт тэтгэвэр авагчдын авч байгаа тэтгэврийг дахин бодуулж шинэчлэн тогтоолоо. Мөн 3Г-ын 120 дугаар тогтоолын Нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 100000 төгрөгөөр нэмэгдүүлэн бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650000 төгрөг, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээг 540000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож 04 дүгээр сарын 01-нээс мөрдөн ажиллаж байна. Дээрх тогтоолуудын дүнд тэтгэвэр тогтоосон цалингийн дундаж 672627 төгрөг, тогтоосон тэтгэврийн дундаж 775815 төгрөг болж өссөн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад дундаж тэтгэврийн хэмжээ 15 хувиар өсчээ.	
						Нийгмийн даатгалын мэдээллийн системийг цолцоор шинэчлэхтэй холбогдуулан гадаадын иргэн, харьяалалгүй 5 тэтгэвэр авагчийн регистрийн дугаарыг Гадаадын иргэн харьяатын газраас олгосон 13 оронтой дугаараар бүртгэсэн боловч 1 хүний мэдээлэл шинэ системд бүртгэгдэхгүй байна.	

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үрсийг хэрэгжүүлэх зорилт

“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, аялага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал буй болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

	Нийгмийн даатгалын сангаас болон ЦАХ-ын тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчийн мэдээллийг системд тавигдсан шаардлагын дагуу үүсгэж тэтгэврийг тогтоож, олгох		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг тогтоосон хугацаанд үзүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.	Тэтгэвэр авагчдын тэтгэвэр олголтын жагсаалт (файл)-ыг бэлтгэхийн өмнө хувийн хэрэг, тэтгэвэр авагчийн мэдээллийн санд оруулсан мэдээллийг үндэслэн тухайн төрлийн тэтгэврийн тогтоолт, олголтын тооцоог тухай бүр бүртгэж, банк тус бүрээр бэлтгэн баталгаажуулж, сар бүрийн 01-ний өдрөөс бүрэн олгож байна. Мөн шинэ тогтоолт болон хөдөлмөрийн чадвар алдалтын сунгалттай тэтгэвэр авагчдын тэтгэврийг долоо хоног бүрийн мягмар гариг бүр 5 банкаар олгож байна. Дорнод аймгийн хэмжээнд 2024 онд тэтгэврийн даатгалын сангаас нийт 14136 тэтгэвэр авагчдад 87880,9 сая төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Үүнд: • Өндөр насны тэтгэвэр 10168 хүнд 70946,5 сая төгрөг • Тахир дутуугийн тэтгэвэр 2631 хүнд 14239,5 сая төгрөг • Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 627 хүнд 3492,3 сая төгрөгийг тус тус олгосон. • Улсын төсвөөс цэргийн 710 тэтгэвэр авагчид 8318,6 сая төгрөг, • 1995 оноос өмнөх тэтгэвэр 694 тэтгэвэр авагчид 538,7 сая төгрөг, • ҮОМШӨ-ний даатгалын сангаас 58 тэтгэвэр авагчид 485,7 сая төгрөгийн тэтгэвэр олгоод байна.
2.1						
2.2	Тэтгэвэр авагчдын шилжилт хөдөлгөөнийг бүртгэн тэтгэврийн олголтын тооцоог хийх,				Тэтгэвэр авагчдын шилжилт хөдөлгөөн: Бусад аймаг дүүргээс шилжиж ирсэн – 74 Шилжиж явсан 89 тэтгэвэр авагчийн хувийн хэргийн бүрдлийг хянан бүртгэж, сар бүрийн олголтыг тулган нууцлалын хавтсанд хийж хүргүүлж ажиллалаа.	

	Тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, хавсаргасан баримтыг тэтгэвэр авагчдын жагсаалттай тулган тооллого явуулах, тэтгэврийн хувийн хэрэг дутсан тохиолдолд шалтгааныг тодруулан шаардлагатай бол нөхөн бүрдүүлэх.				Мөн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгасан-2665, НДШ төлсөн хугацааг нэмж тооцуулсан 287, жишиг цалингаар өөрчлөн тогтоолгосон 2 тэтгэвэр авагчийн мэдээллийг хянан шалгаж тэтгэврийг өөрчлөн тогтоосон байна. Тэтгэвэр авагчдын хүсэлтийн дагуу 825 иргэний тэтгэвэр олгох банкийг шилжүүлээ.	
2.3		2024 тэтгэвэр авч байсан бүх тэтгэвэр авагчийн хувийн хэргийг бүрэн хамруулна.	Нийгмийн даатгалын санд өмнөх онд орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажигласан байна.	Хэрлэн сумын тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг Хяналт шалгалтын тасалтай хамтран зохион байгуулсан. Өндөр насны тэтгэвэр 6521, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 1673, тэжээгч алдсаны тэтгэвэр 428 нийт 8622 хувийн хэрэг бүрэн тоологдсон. Мөн бусад сумдын тэтгэврийн хувийн хэргийн байцаагч нар өөрсдөө тоолсон бөгөөд хувийн хэрэг бүрэн тоологдсон байна.	
2.4	Ажил олгогч, даатгуулагчаас илгээсэн хүсэлтийн дагуу нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийг тогтоож, олгох	Ажил олгогч даатгуулагчаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэнэ.			Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөр чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах нийт 348 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авснаас хуульд заасан эрх үүсээгүй, материалын үндэслэл хангаагүй зэрэг шалтгаанааар 143 даатгуулагчийн материалыг хяналтын шатанд буцааж, 3945 даатгуулагчид 3351,4 сая төгрөгийн тэтгэмжийг хугацаанд нь олгон ажиглаа. Үүнээс: • ХЧТА тэтгэмж 414,6 сая төг • ЖА тэтгэмж 2248,8 сая төг • Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж 688,0 сая төг Нийт олгосон тэтгэмжийг өмнөх оныхтой харьцуулахад хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 2.9 хувиар буюу 12.1. сая төгрөгөөр	

					буурч, жирэмсэн амаржсаны тэтгэмж 13.8 хувиар буюу 360.7 сая төгрөгөөр өссөн байна. Цахим шилжилтийн хүрээнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны нийт 3600 даатгуулагчийн хүсэлтийг 100 хувь цахимаар хүлээн авсан байна.	
	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн анхан болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах.		НДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын гэлтийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд нийгмийн даатгалын байгууллага өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулсан анхан шатны 51 төрлийн маягт, түүнийг хөтлөх зааврыг мөрдөн ажиглаж байна. • Тэтгэврийн хувийн хэрэг Б-НД-4, Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлант улирал бүр (4 удаа), сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ (12 удаа)-г сар бүр, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээ судалгааг тухай бүр нь үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлэн ажиглаж байна.	
2.5		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлант үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	2023 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан	Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд	Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн дагуу холбогдох байгууллагуудаас зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиглах мэргэжилтнүүдийн саналыг албан бичгээр авч нэгтгэн, ерөнхий газарт хүргүүлсэн. Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан 10 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн зохион байгуулагдаж 46 удаагийн хурлаар нийт 2728 ирээний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь	
2.6	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиглах					

					2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	Хугацааг шийдвэрлэсэн байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар иргэдийн оношийн баталгаажилтыг төрөлжсөн мэргэжлийн эмч нар тогтмол хянаж, оношийн бүрдэл дутуу, баталгаажилт хангалтгүй, хяналтын үзлэг хангалтгүй зэрэг 48 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлсэн байна.
		Сургалт, өдөрлөг, цахим сурталчилгааны тоо, мэдээлэл авсан иргэдийн тоо, тайлан	2023 онд 2-аас доошгүй удаагийн сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгсөн	Эрүүл мэндийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн магадлалын талаар мэдээлэл өгч, иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгаа хийж ажилласан байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 46 удаагийн хурлаар шийдвэрлэсэн нийт 2728 иргэний мэдээллийг зөвлөлийн мэдээллийн санд үнэн, зөв бүрдүүлсэн эсэхэд тухай бүр хяналт тавьж ажиглав. Хяналтын явцад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, сунгалтын он сар өдөр, оношийн код буруу 12, өвчний ангилал буруу 4 тохиолдлыг тус тус илрүүлэн, залруулах арга хэмжээ авав. Түүнчлэн тэтгэвэр авагчдын массивыг, зөвлөлийн хурлын мэдээллийн сантай тулган шилжиж явсан 18, шилжиж ирсэн 6, нас барсан 59, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил буруу 3 иргэний хөдөлгөөнийг засч бүртгэлийг шинэчлэн засварласан байна.	
2.7	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх					
	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн	Хэрэгжүүлсэн үүрэг,	2024 онд 5 үүрэг	Дээд өгсөн	газраас чиглэл,	

акт, шаардлагын биелэлтийг хангуулах,		даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо	даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг төв зөвлөлд хүргүүлэн ажилласан.	зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажигласан байна.
Ажил олгогч, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах,		-Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2023 онд 98%-тай хэрэгжсэн байна.	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна. Тэтгэвэр авагч, даатгуулагчдаас ирүүлсэн тэтгэвэр тогтоолгосон хугацаагаа дахин шалгуулах 24, хөдөлмөрийн нөхцөл шалгуулах 9 хүсэлтүүдийг хугацаанд хянан шалгаж шийдвэрлэсэн байна. Мөн жирэмсэн амаржсаны тэтгэмж, нас барсан иргэдэд олгох мөнгөн тэтгэмж олгох хугацааны асуудлаар гаргасан гомдлыг дахин нягтлан даатгуулагчдын эрх ашгийг ханган ажиллалаа.
2.8 Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
3.1 Даатгуулагчдад нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн чиглэлээр сургалт зохион байгуулах;	- Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх. Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна.	Иргэд, даатгуулагчид чиглэсэн 12 удаагийн сургалтад 682 иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг хамруулсан байна.	“Дорнод” сонинд Нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн шинэчилсэн найруулга, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, үйл ажиллагааны талаар болон цаг үеийн мэдээлэл бэлдэн 5 удаагийн дугаарт хэвлүүлсэн байна Нийгмийн цогц үйлчилгээний хүрээнд сумдын байцаагч нар 738 малчинд нийгмийн даатгалын ач холбогдол, малчны сайн дурын даатгалын хөнгөлөлтийн талаар сурталчилан 140 гаруй малчны тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг үзэж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

					Нийгмийн даатгалын газрын пейж хуудаснаас гадна харилцагч ажил олгогчдын, сайн дурын даатгуулагчдын болон сүм бүрийн нийгмийн даатгалын фэйсбүүк хаягийг ажиллуулан харилцан мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлэн дагалчдын тоог нэмэгдүүлж мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.	
		Цахим мэдээл- лийн хэрэгслээр сурталчилгаа хийх, Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, улрал бүр;	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагага й хамтран ажилласан байна.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.	“Дорнод” сонинд Нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн шинэчилсэн найруулга, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, үйл ажиллагааны талаар болон цаг үеийн мэдээлэл бэлдэн 10 удаагийн дугаарт хэвлүүлсэн байна Нийгмийн цогц үйлчилгээний хүрээнд сумдын байцаагч нар 738 малчинд нийгмийн даатгалын ач холбогдол, малчны сайн дурын даатгалын хөнгөлөлтийн талаар сурталчилсан 140 гаруй малчны тэтгэвэр тогтоолох баримт бичгийг үзэх, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна. Нийгмийн даатгалын газрын пейж хуудаснаас гадна харилцагч ажил олгогчдын, сайн дурын даатгуулагчдын болон сүм бүрийн нийгмийн даатгалын фэйсбүүк хаягийг ажиллуулан харилцан мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлэн дагалчдын тоог нэмэгдүүлж мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.	
3.2	Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах;					

Дөрөв. “НЭГГЖИЙН ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХАНГАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

4.1	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2022 онд 88,1	Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д болон иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь төрөөс нийгмийн даатгалын талаар баримтлаж буй бодлого, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх, хууль сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна	
-----	--	--	--	---	--	--

	дүнг хуулийн хугацаанд тайлагнах.	дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	%-тай хэрэгжсэн байна.	өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, тэдний тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах.	Тус хэлтэст 2024 онд иргэд, даатгуулагчаас нийт 8246 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсний бичгээр ирсэн 8246 өргөдөл ирсэн байна. Бичгээр ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь ангилбал: - Тэтгэвэр тогтоолгох, өөрчлөн бодуулах – 1347, - Тэтгэмж, зардал олгуулах - 4235, - Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх, буцаан олгуулах – 286 - Нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагаа авах – 2315 -Хөдөлмөрийн чадвар дахин тогтоолгох – 2 -Хөдөлмөрийн нөхцөл тогтоолгох -4 -Дотоод үйл ажиллагаатай холбоотой - 31
					Дээрхи өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэж ажиллалаа.
4.2	Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх.	Нийгмийн даатгалын хэлтэс дотсоддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна.	Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна.	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн архивт Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23.2-т заасан чиг үүргийн дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой удирдлагын байнга болон түр хадгалах, 70 жил хадгалагдах аж ахуй нэгжийн болон, даатгуулагчийн шимтгэл төлөлттэй холбоотой баримт хадгалагдаж байгаа бөгөөд хадгаламжийн нэгжийг нөхөн баяжуулах, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх, тоо бүртгэл хөтлөх, архивын баримтыг байцаагч ажилтнууд болон хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу бүртгэл хөтлөн ашиглуулах, байгууллага иргэдэд тус хуулийн 2.1.7-д зааснаар цаасан суурьт болон цахим мэдээллийн сангаас лавлагаа мэдээллээр үнэ төлбөргүй үйлчлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй

					үзүүлэх ажлын хүрээнд “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн “Нийгмийн даатгалын байгууллагын архиваас лавлагаа олгоход баримтлах зөвлөмж”-ийн дагуу 2024 онд иргэдээс ирсэн архивын лавлагаа авах хүсэлтийн дагуу QR код бүхий цахим лавлагааг олгон хэлтэс дотооддоо болон бусад аймаг, дүүргийн хэлтэс хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгууллаа. Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сангаас 1860 даатгуулагчид, хэлтсийн архивын баримтаас 455 лавлагаа гаргасан. Үүний 43 лавлагааг 4 аймаг, 4 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж ажилласан байна.	
4.3	Байгууллагын болон албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх дэв-	Хэрэгжилт хувиар	100	100	Өнгөрсөн онд хэлтэс, тасаг, сумдын байцаагчаас албан, хэрэг хөтлөлтийн явцад үүссэн буюу аж ахуйн нэгж, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайлан тооцоо, тэтгэвэр, тэтгэмжийн олголт болон сангийн холбогдох 296 хадгаламжийн нэгж, тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаад зогсоогдсон 623 тэтгэвэр аватчийн хувийн хэргийг бүртгэлд оруулан энэ оны I улиралд багтаан нөхөн бүрдүүлэлт хийсэн. Мөн нөхөн бүрдүүлэлтээр Батлан хамгаалахын төв архиваас Зэвсэгт хүчний 085 дугаар ангийн 1995-1996 оны ажиллагсдын шимтгэлийн төлөлтийн 2 баримт, Хил хамгаалах ерөнхий газрын архиваас хилийн цэргийн 0198 дугаар ангийн 1995-2000 оны хугацаат цэргийн албан хаагчдын нэрс 193 хуудас 11 баримт ирсэнийг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авлаа. Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим үндэстэн” болох арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын байгууллага нь 23	

	шилтэт технологи, арга хэлбэрийг нэвтрүүлэн ажиллах		Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилгыг давхардуулахгүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох.	Хэлтсийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байна.	Хэлтсийн дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна.	Үйлчилгээг цахим хэлбэрт шил үйлчилгээ төрийн цахим үйлчилгээ тоогойга.тп системд холбогдоод бэ Нийгмийн даатгалын мэдээллийг 2024 оноос шинэчлэгдсэнтэй гаддаадын иргэн, харьяалалгүй авагчийн регистрийн дугаарыг Гад харьяатын газраас олгосон дугаараар өөрчлөн бүртгээд Хөдөлмөр нийгмийн хамгааллыг ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн аватчийн хувийн хэргийг цахимж, зохион байгуулан ажиллаж байна. тэтгэвэр авагчийн хувийн цахимжуулахаар ажилтнууд уртасч ажиллаж байна. Цахимжуулах аж гүйцэтгэлтэй явагдаж байна.
4.4	Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх		Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилгыг давхардуулахгүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох.	Хэлтсийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байна.	Хэлтсийн дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна.	Хэлтсийн дотоод ажлыг сайжруул: шинэлэг ажил зохион байгуулах аж доорх ажлыг зохион байгуулав. Үүн, - Монгол улсын засгийн газрын 21 дугаар тогтоолд "Алсын хараа-21 Улсын урт хугацааны хөгжлийн бо, сэрлэлтийн бодлого"-ыг бүх шатны хаагч, ажилтнуудад таниулах гэж ту 'Алсын хараа 2050' монгол улсын ү хөгжлийн бодлого, түүний эхний ү сэрлэлтийн бодлогын богино хугац сэдэвт сургалтад нийт ажилтнууд хувийг хамрууллаа. Сургалтыг академийн багш нар удирдан яв болон танхимын хосолсон сурга хамрагдсан 32 албан хаагчид гарчи - Төрийн байгууллагуудтай хамтра цогц явуулын үйлчилгээ"-г Халх тс Баяндун, Чойбалсан, Чулуунхор зохион байгуулан нийт 175 хү

					даатгалын үйлчилгээг үзүүлсэн байна. Энэхүү үйлчилгээнд эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, соёл, урлаг, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, мал эмнэлэг, улсын бүртгэл, ахуйн үйлчилгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг олон талын үйлчилгээ багтаж байгаа юм. Үүний үр дүнд хөдөөгийн малчид нийгмийн үйлчилгээ авахын тулд сум, аймгийн төвийг зорихгүйгээр цаг хугацаа, санхүүгээ хэмнэхээс гадна аливаа өвчлөлийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлүүлэх боломж нэмэгдэнэ. Мөн сумдад зохион байгуулсан "Малчдын зөвлөгөөн"-д оролцон Нийгмийн даатгалын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар болон малчинь тэтгэвэр тогтооход анхаарах асуудал, малчинь нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг хөнгөлөлтийн талаар мэдээлэл хийж ажиллалаа.	
--	--	--	--	--	--	--

Гүйцэтгэлийг хянасан: Төсвийн шүүмэл захирагч
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА ДАРИУНБОЛД

Гүйцэтгэлийг тайлагнасан:
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА И.ТӨГСБАЯР

.....
(огноо)